



ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ  
“ГАН ХИЙЦ”  
ХУВЬЦААТ КОМПАНИ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 02-сарын 15-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал  
зарлан хуралдуулах тухай

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 11:40 цагаас компанийн хурлын байранд хуралдуулахаар зарласугай.
2. Дээрх хурлаар хэлэлцэх асуудлыг дор дурьдсанаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулахаар баталсугай. Үүнд:
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
  - Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
  - ТУЗ-ийн 2023 оны зардлын төсөв, Компанийн үйл ажиллагааны 2023 оны зардлын төсөв батлах
  - Ноогдол ашгийн талаар мэдээлэл танилцуулах
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтын дагуу баталсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД



М.ДАВААСҮРЭН

Б.ГАНТУЛГА

Э.ДӨЛГОРСҮРЭН

Д.ЭНХБААТАР

Б.ЭРДЭНЭБАЯР

Ц.ХАНГАЙ

П.ТӨВСАНАА

Ц.ЖАНЛАВ



ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ  
“ГАН ХИЙЦ”  
ХУВЬЦААТ КОМПАНИ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 15-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02-р сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

- 2022 оны үйл ажиллагааны цэвэр ашгийг 624,204,000 (зургаан зуун хорин дөрвөн сая хоёр зуун дөрвөн мянга)-н төгрөгөөр батлаж үйл ажиллагааны 90 хувь болох 561,783,600 (таван зуун жаран нэгэн сая долоон зуун наян гурван мянга зургаан зуу)-н төгрөгийг 2023 онд компанийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах ажилд зарцуулж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (М.Даваасүрэн)-д даалгасугай.
- Нийт ашгийн 10 хувь болох 62,400,000 (жаран хоёр сая дөрвөн зуун мянга)-н төгрөгийн 24,246,400 (хорин дөрвөн сая хоёр зуун дөчин зургаан мянга дөрвөн зуу)-н төгрөгийг ногдол ашгийн нэгж хувьцаанд 100 төгрөгөөр тогтоож, холбогдох Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан олгох, үлдэгдэл 38,177,600 (гучин найман сая нэг зуун далан долоон мянга зургаан зуу)-н төгрөгийг удирдлага менежментийн багт урамшуулал болгон олгохыг гүйцэтгэх захирал (Д.Оюунзул)-д зөвшөөрсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД



М.ДАВААСҮРЭН

Б.ГАНТУЛГА

Э.ДОЛГОРСҮРЭН

Д.ЭНХБААТАР

Б.ЭРДЭНЭБАЯР

Ц.ХАНГАЙ

П.ТӨВСАНАА

Ц.ЖАНЛАВ